

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

*1994 оны 5 дугаар сарын 12-ны өдөр
Улаанбаатар хот*

ВАЛЮТЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь валютын зохицуулалтын талаарх төрийн зохих байгууллагын бүрэн эрхийг тодорхойлж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд валютын гүйлгээ хийх, валютын гүйлгээнд хяналт тавих, Монгол Улсын үндэсний валютыг үнэгүйдлээс хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Валютын зохицуулалтын тухай хууль тогтоомж

1. Валютын зохицуулалтын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөр журам тогтоосон бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

1. "Валют" гэж Монгол Улсын үндэсний валют, гадаад валют, улс хоорондын худалдаа, эдийн засгийн харилцааны төлбөрт хэрэглэгдэж буй тооцооны нэгж, мөнгөжсөн алт болон валютын үнэт зүйлсийг хэлнэ.

2. "Үндэсний валют" гэж эргэлтэд байгаа төлбөрийн чадвар бүхий Монгол Улсын мөнгөн тэмдэгт-төгрөг, түүгээр илэрхийлэгдсэн бөгөөд олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг үнэт цаас, төлбөрийн хэрэгслийг хэлнэ.

3. "Гадаад валют" гэж эргэлтэд байгаа төлбөрийн чадвар бүхий нэг буюу хэд хэдэн гадаад улсын мөнгөн тэмдэгт, тэдгээрээр илэрхийлэгдсэн бөгөөд олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг үнэт цаас, төлбөрийн хэрэгслийг хэлнэ. Гадаад валютыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрснөөр чөлөөтэй хөрвөдөг ба чөлөөтэй хөрвөдөггүй гэж ангилна.

4. "Мөнгөжсөн алт" гэж олон улсын жишигт хүргэн цэвэршүүлж, олон улсын санхүүгийн аль нэг төвд хадгалуулж байгаа, гадаад валютаар борлуулахад бэлэн болсон алтыг хэлнэ.

5. "Валютын үнэт зүйлс" гэж мөнгөжсөн алттай адилтгах үнэт металл, эрдэнийн чулууг хэлнэ.

6. "Цэвэршүүлсэн алт" гэж алтны агуулгыг нь нэмэгдүүлж цэвэршүүлсэн боловч гадаад валютаар шууд борлуулах нөхцөл хангагдаагүй алтыг хэлнэ.

7. Валютын харилцаанд оролцогч байнга оршин суугч /цаашид "байнга оршин суугч" гэх/ гэж:

1/ Монгол Улсад байнга оршин суугаа, мөн байнга оршин суудаг боловч 183 хоногоос дээшгүй хугацаагаар гадаадад зорчиж байгаа хувь хүн;

2/ Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, Монгол Улсад оршин байрладаг хуулийн этгээд, түүний гадаадад байгаа салбар, төлөөлөгчийн газар;

3/ гадаад улсад суугаа Монгол улсын дипломат төлөөлөгчийн газрыг тус тус хэлнэ.

8. Валютын харилцаанд оролцогч түр оршин суугч /цаашид "түр оршин суугч" гэх/ гэж:

1/ Монгол Улсын гадна байнга оршин суудаг, мөн Монгол Улсад 183 хоног хүртэл хоногийн хугацаагаар байгаа хувь хүн;

2/ гадаад улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, Монгол улсад оршин байрладаггүй хуулийн этгээд, түүний Монгол Улс дахь салбар, төлөөлөгчийн газар;

3/ Монгол Улсад байгаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн газар болон олон улсын байгууллага, тэдгээрийн салбар, төлөөлөгчийн газрыг тус тус хэлнэ.

4 дүгээр зүйл. Монгол Улсын валютын гадаад нөөц

1. Монгол Улсын валютын гадаад нөөц нь төрийн эрх бүхий байгууллагын болон арилжааны банкны эзэмшилд байгаа:

1/ гадаад орны банк, санхүүгийн байгууллагад хадгалж байгаа мөнгөжсөн алт;

2/ чөлөөтэй хөрвөдөг гадаад валют;

3/ гадаадад чөлөөтэй төлөгдөх болон гадаадын үнэт цаасны зах дээр борлогдох бүх төрлийн үнэт цаас;

4/ энэ хэсгийн 1, 2-т зааснаас бусад олон улсын хэмжээнд валютын нөөцөд тооцогддог үнэт зүйлийн активаас бүрдэнэ.

2. Төрийн өмчид байгаа энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зүйл нь төрийн эрх бүхий байгууллагын эзэмшилд байгаа валютын гадаад нөөцөд хамаарна.

3. Монгол улсын болон төрийн эрх бүхий байгууллагын эзэмшилд байгаа валютын гадаад цэвэр нөөцийг валютын гадаад нөөц тус бүрийн нийт дүнгээс гадаадаас авсан холбогдох богино хугацаат зээл, хадгаламжийг хасаж тодорхойлно.

5 дугаар зүйл. Монгол Улсын валютын зах, ханш

1. Эрх бүхий банк, бирж, брокерийн компаниас эрэлт нийлүүлэлтийн үндсэн дээр хийж байгаа валютын худалдаа арилжааны үйл ажиллагааг Монгол Улсын валютын зах гэнэ.

2. Монголбанк төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг валютын зах дээр арилжааны банкуудын худалдсан, худалдаж авсан гадаад валютын ханшид үндэслэн тус улсын гадаад худалдаанд зонхилон хэрэглэж байгаа тогтвортой ханш бүхий чөлөөтэй хөрвөдөг аль нэг гадаад валютын тухайн үеийн ханштай жишин тогтоож нийтэд зарлана.

3. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг урьд өдрийн ханшаас 5 буюу түүнээс дээш хувийн хэлбэлзэлтэйгээр өсгөх буюу бууруулах тохиолдолд монгол Улсын Ерөнхий сайдтай зөвшилцөнө. Зөвшилцөөнд хүрээгүй нь Монголбанкны Ерөнхийлөгч шийдвэр гаргахад саад болохгүй.

4. Арилжааны банк нь валютын захын эрэлт хэрэгцээнд үндэслэн валют худалдах, худалдан авах өөрийн ханшийг тогтооно.

5. Төсөв, гаалийн тооцоонд Монголбанкнаас тогтоосон ханшийг хэрэглэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Валютын зохицуулалтын талаар төрийн байгууллагуудын эдлэх бүрэн эрх

6 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

Улсын Их Хурал валютын зохицуулалтын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ валютын талаарх төрийн бодлогыг тодорхойлох;
2/ гадаадаас авах Засгийн газрын зээл, Монгол Улсын гадаад төлбөрийн тэнцлийн төслийг хянан шийдвэрлэх;

3 /төрийн өмчид байвал зохих валютын гадаад цэвэр нөөцийн доод хэмжээг тогтоох;

4/ улсын нөөцөд байгаа цэвэршүүлсэн алтыг валютын гүйлгээнд оруулах тухай шийдвэр гаргах;

5/ хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

7 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

Засгийн газар валютын зохицуулалтын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ гадаад валютын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, төлбөрийн тэнцлийг сайжруулах арга хэмжээ авах;

2/ Монгол Улсын гадаад төлбөрийн тэнцэл зохиож, биелэлтэд нь хяналт тавих;

3/ гадаадаас авах Засгийн газрын зээл, түүний төлбөртэй холбогдсон санал боловсруулах хэрэгжүүлэх;

4/ хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

8 дугаар зүйл. Монголбанкны бүрэн эрх

Монголбанк нь валютын зохицуулалтын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ улсын хэмжээнд валютын гүйлгээг зохицуулж, хэрэгжүүлэх;

2/ улсын валютын гадаад нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;

3/ Монгол Улсын болон гадаадын валютын зах дээр эрх хэмжээнийхээ дотор валютын гүйлгээ, гадаад төлбөр, тооцоо эрхлэх;

4/ төрийн өмчид байвал зохих валютын гадаад цэвэр нөөцийн доод хэмжээ тогтоох тухай санал боловсруулж шийдвэрлүүлэх, түүнийг хадгалах, оновчтой, үр ашигтай байршуулах;

5/ Засгийн газрын валютын гүйлгээ, гадаад төлбөр, тооцоог гүйцэтгэх;

6/ байнга оршин суугчид гадаад төлбөр, тооцоо хийх болон гадаад бэлэн валютаар гүйлгээ эрхлэхэд хяналт тавих;

/Энэ заалтыг 2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

7/ валютын гүйлгээний тайлан, мэдээ гаргах журмыг тогтоох;

8/ валютын гүйлгээний нэгдсэн тайлан, мэдээг Улсын Их Хуралд улирал бүр оруулж байх;

9/ хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

ГУРАВДУГААР БҮЛЭГ Валютын гүйлгээ хийх

9 дүгээр зүйл. Валютын гүйлгээ

1. Валют худалдах, худалдан авах, хадгалах, зээлдэх, шилжүүлэх, байршуулах, барьцаалах, улсын хилээр оруулах, гаргахтай холбоотой үйл ажиллагааг валютын гүйлгээ гэнэ.

2. Банк нь гадаад валютын гүйлгээг түүнтэй тэнцэх хэмжээний үндэсний валютын гүйлгээтэй нэгэн зэрэг гүйцэтгэнэ.

3. Монгол Улсын үндэсний валют, чөлөөтэй хөрвөдөггүй гадаад валютыг Монгол Улсын хилээр оруулах, гаргах, валютын гүйлгээнд ашиглах журмыг Монголбанкны ерөнхийлөгч, Сангийн сайд хамтран батална.

10 дугаар зүйл. Монголбанкны эрхлэх валютын гүйлгээ

1. Монголбанк нь Монгол Улсын валютын гадаад нөөцийг нэмэгдүүлэх, зохицуулах зорилгоор тус улсын болон гадаад орны банк, бусад аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс валют, цэвэршүүлсэн алт худалдан авч болно.

2. Монголбанк нь төгрөгийн ханшийг тогтвортой байлгах зорилгоор өөрийн эзэмшилд байгаа валютын гадаад нөөцөөс гадаад валютыг худалдана.

11 дүгээр зүйл. Арилжааны банкны эрхлэх валютын гүйлгээ,эрх, үүрэг

1. Арилжааны банк нь Монголбанкнаас олгосон зөвшөөрлийн хүрээнд валютын гүйлгээний дараахь үйл ажиллагааг эрхэлж болно:

1/ гадаад валютын бэлэн бус төлбөр, тооцооны үйл ажиллагаа эрхлэх;

2/ гадаад валютыг бэлнээр худалдах, худалдан авах;

3/ байнга болон түр оршин суугчдын нэр дээр гадаад валютын данс нээж, гүйлгээ хийх;

4/ гадаад валютаар зээл олгох, баталгаа гаргах зэрэг актив, пассивын бүх төрлийн ажил, гүйлгээ эрхлэх.

2. Валютын гүйлгээ эрхэлж байгаа арилжааны банк дараахь үүрэгтэй байна:

1/ валютын гүйлгээний талаарх тайлан, мэдээг тогтоосон журмын дагуу гаргах, мэдээлж байх;

2/ төгрөгийн ханшид нөлөө үзүүлэхүйц гүйлгээг Монголбанкны зөвшөөрлөөр гүйцэтгэх;

3/ харилцагчийнхаа гадаад валютын дансны нууцыг хадгалж, найдвартай байдлыг хангах;

4/ гадаад валютын гүйлгээг харилцагчийн анхны шаардлагаар хийх, хөрөнгийнх нь үлдэгдэлд хүү төлөх.

3. Арилжааны банк нь гадаад валютын ажил, үйлчилгээндээ ногдуулах шимтгэлийг өөрөө тогтооно.

12 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн гадаад валютын гүйлгээ

1. Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн 2, 3 мөн зүйлийн 8 дахь хэсэгт заасан байнга буюу түр оршин суугчид нь гадаад валютыг худалдах, худалдан авах болон зээлдэх, шилжүүлэх ажиллагааг зөвхөн Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэнэ.

2. Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн 2, 3-т заасан байнга оршин суугч нь орлогоо гадаад валютаар бэлнээр буюу бэлэн бус төлбөрийн хэрэгслээр авсан бол Монголбанкнаас эрх олгосон арилжааны банкинд уг орлогыг авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор худалдах буюу хадгалуулна.

3. Гадаад бэлэн валютаар ажил, үйлчилгээ эрхэлж буй энэ хуулийн 3 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн 2-т заасан байнга оршин суугч нь өдөр тутмын гүйлгээ хийхэд шаардагдахаас бусад гадаад валютыг Монголбанкнаас тогтоосон журмын дагуу зохих хугацаанд банкинд худалдах буюу хадгалуулна.

/Энэ хэсэгт 2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

4. Монгол Улсын иргэд болон энэ хуулийн 3 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн 2,3-т заасан байнга оршин суугч нь гадаадад хөрөнгө байршуулах, зээл тусламж олгохдоо Сангийн яаманд бүртгүүлнэ.

5. Байнга болон түр оршин суугч нь арилжааны банкнаас гадаад валют худалдан авах, зээлдэх, банкинд худалдах, зээлдүүлэх гэрээ, зээлийн баталгааг бичгээр үйлдэнэ.

13 дугаар зүйл. Валютыг Монгол Улсын хилээр оруулах, гаргах

1. Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн валютыг гаалийн байгууллагад бичгээр мэдүүлсэн тоо, хэмжээгээр тус улсын хилээр оруулж болно.

2. Монгол Улсад байнга болон түр оршин суугч гадаадын иргэн, харьяалалгүй хүн валютыг дор дурдсан журмаар тус улсын хилээр гаргаж болно:

1/ гадаад төлбөр, тооцооны эрх бүхий арилжааны банкнаас худалдан авсан, чөлөөтэй хөрвөдөг гадаад валютыг тухайн банкны нотолгоо бичгээр;

2/ гадаадаас оруулж ирсэн бол түүнийгээ нотлох гаалийн мэдүүлгээр;

3/ өв залгамжлан авсан болон бусдаас бэлэглэсэн бол үүнийгээ тус улсын нотариатын байгууллагын нотолгоо бичгээр;

4/ Монгол Улсын хууль тогтоомжид зааснаар.

3. Монгол Улсын иргэн чөлөөтэй хөрвөдөг гадаад валютыг хуулиар хязгаар тогтоогоогүй бол гаальд мэдүүлсэн тоо хэмжээгээр тус улсын хилээр гадаадад гаргаж болно.

14 дүгээр зүйл. Гадаад валютын зээл, төлбөр тооцоо

1. Гадаад орон болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас Засгийн газрын шугамаар авсан гадаад зээл тусламжийн нэгдсэн бүртгэлийг Сангийн яам хөтөлнө.

2. Засгийн газрын шугамаар авах гадаад зээлийн баталгааг Засгийн газрын зөвшөөрснөөр Сангийн сайд гаргана. Сангийн сайдын баталгаагүй авсан зээлийн төлбөрийг Засгийн газар хариуцахгүй.

3. Гадаад орон болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл, тусламжийн хөрөнгийг Засгийн газар нь Монголбанк болон түүнээс гадаад төлбөр, тооцооны эрх олгосон арилжааны банк, бусад аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр худалдах буюу зээлдүүлж болно.

4. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан зээлийн гэрээнд хүү, төлөх хугацаа, зориулалт, хүлээх хариуцлага зэргийг талууд харилцан тохиролцож тусгана.

5. Засгийн газрын гадаадаас авсан зээлийг ашиглагч банк, бусад аж ахуйн нэгж, байгууллага нь уг зээлийг эргүүлж төлөх хөрөнгийн эх үүсвэрийг тухай бүр бүрдүүлж төсөвт төлнө.

6. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн өөрсдийн гадаадаас авсан валютын зээлийг Монгол банкинд бүртгүүлнэ.

/Энэ хэсгийг 2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

7. Төсвийн санхүүжилтээр хийх гадаад төлбөрийг зөвхөн тухайн санхүүгийн байгууллагын зөвшөөрлөөр гүйцэтгэнэ.

8. Сангийн яам нь Засгийн газрын валютын гүйлгээ, гадаад төлбөр тооцоог банкаар дамжуулан хийнэ.

9. Байнга болон түр оршин суугч нь Монголбанкнаас гадаад төлбөр, тооцооны эрх олгосон арилжааны банк болон тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын банкны салбарт гадаад валютын данстай байж болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Валютын гүйлгээнд тавих хяналт

15 дугаар зүйл. Хяналт тавих байгууллага

Монгол Улс дахь аж ахуйн нэгж, байгууллагын валютын гүйлгээнд Засгийн газар Монголбанк өөрсдийн бүрэн эрхийн дагуу хяналт тавина.

16 дугаар зүйл. Валютын хяналтын улсын байцаагч

1. Валютын хяналтыг Улсын ерөнхий байцаагч, Улсын ахлах байцаагч, улсын байцаагчид хэрэгжүүлнэ.

2. Валютын хяналтын улсын ерөнхий байцаагч нь Монголбанкны ерөнхийлөгч, Улсын ахлах байцаагч нь валютын асуудлыг эрхэлсэн Монголбанкны дэд ерөнхийлөгч байна.

3. Валютын хяналтын улсын байцаагчийг Улсын ерөнхий байцаагч томилно.

17 дугаар зүйл. Валютын хяналтын байгууллагын үүрэг, улсын байцаагчийн бүрэн эрх

1. Монголбанк нь дараахь үндсэн үүрэгтэй байна:

1/ валютын зохицуулалтын тухай хууль тогтоомжийн биелэлтийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад өмчийн төрөл, хэлбэр, харьяалал харгалзахгүйгээр хянан шалгах;

2/ валютын гүйлгээтэй холбоотой баримт, сэлтийг шалгах;

3/ валютын гүйлгээ, гадаад төлбөр, тооцооны ажиллагааны талаарх бүртгэл, тайлан мэдээний үнэн зөвийг шалгах;

4/ эрх бүхий байгууллагаас хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан эрхийн актыг валютын гүйлгээнд мөрдөж байгааг шалгах.

2. Засгийн газар Монгол улсын олон улсын гэрээ, хуульд заасан үндэслэлээр өөрийн эзэмшилд байгаа валютын ашиглалт, зарцуулалтад хяналт тавих бөгөөд ийнхүү хяналтаа Сангийн ямаар дамжуулан хэрэгжүүлнэ.

3. Улсын байцаагч нь валютын хяналтын үүргээ биелүүлэхдээ дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ валютын гүйлгээ, гадаад төлбөр, тооцоонд холбогдох баримт сэлтийг үзэх, холбогдох албан тушаалтан, иргэнээс мэдээ тодорхойлолт, тайлбар, шаардлагатай баримтын хуулбарыг гаргуулан авах;

2/ валютын гүйлгээ, төлбөр, тооцоог хянах, шалгалтын дүнгээр акт тогтоож, гүйцэтгэлийг хангах. Улсын байцаагчийн акт нь валютын хяналтын Улсын ерөнхий буюу Улсын ахлах байцаагчийн баталснаар хүчин төгөлдөр болно. Тавьсан актад холбогдох албан тушаалтан, иргэнээр гарын үсэг зуруулна. Тэдгээрээс уул актыг хүлээн зөвшөөрөхгүй бол тайлбар гаргуулна;

3/ илэрсэн зөрчлийг арилгах талаар хугацаатай үүрэг өгөх, шаардлага тавих;

4/ тавьсан шаардлагыг биелүүлээгүй, хууль тогтоомж зөрчсөн этгээдэд энэ хууль болон бусад хуульд заасан захиргааны хариуцлага хүлээлгэх;

5/ хуулийн заалтыг зөрчсөн бол гадаад төлбөр, тооцоо хийх, валютын гүйлгээ эрхлэх зөвшөөрлийг цуцлах талаар валютын хяналтын Улсын ерөнхий байцаагчид санал тавих;

6/ валютын зохицуулалтын тухай хууль тогтоомж зөрчсөн нь гэмт хэргийн шинжтэй байвал холбогдох баримт, сэлтийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагад шилжүүлэх.

4. Валютын хяналтын улсын байцаагч нь валютын үйл ажиллагаанд тавих хяналтын явцад олж мэдсэн иргэд, байгууллага, банк, бусад аж ахуйн нэгжийн валютын хөрөнгө, худалдааны нууцыг хадгалах үүрэгтэй.

5. Валютын хяналтын байгууллагын албан тушаалтан нь үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд түүнд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

6. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн валютын гүйлгээний талаарх маргааныг шүүхээр шийдвэрлэнэ.

18 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

1. Валютын зохицуулалтын тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол дор дурдсан захиргааны шийтгэлийг ногдуулна:

1/ энэ хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалтыг зөрчсөн иргэнийг 5000-50000, байгууллага, аж ахуйн нэгжийг 50000- 250000 төгрөгөөр, мөн зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн байгууллага, аж ахуйн нэгжийг 50000-100000 төгрөгөөр торгох;

2/ энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2, 3, 4 дэх заалтыг зөрчсөн бол 50000-100000 төгрөгөөр торгох;

/Энэ заалтад 2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

3/ энэ хуулийн 14 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн заалтыг зөрчсөн иргэнийг 50000 хүртэл, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000хүртэл төгрөгөөр торгох;

4/ энэ хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн иргэнийг 20000-50000, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000- 100000 төгрөгөөр торгох;

5/ Монголбанкны зөвшөөрөлгүйгээр буюу олгогдсон зөвшөөрлийн хүрээнээс гадуур энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар олсон орлогыг хурааж, 50000-250000 төгрөгөөр торгох.

/Энэ зүйлийг 1995 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулж, 4,5 дахь хэсгийг нэмсэн/.

2. Валютын зохицуулалтын тухай хууль тогтоомж зөрчсөнөөс бусдад учруулсан хохирлыг гэм буруутай этгээдээр хууль тогтоомжийн дагуу нөхөн төлүүлнэ.

19 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1994 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА**

Н. БАГАБАНДИ